

*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*



**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-7

---

<i>1. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	4-7
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
06 дугаар сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Д.Батлут, С.Ганбаатар, ОЦогтгэрэл;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн.

**Нэг.Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх Э.Мэндсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Эрхэмбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ц.Амгалан, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэбат, Арьс шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Г.Ганболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Т.Энхтүвшин нар үг хэлэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Г.Ганболд:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Тогтоолын төслийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	2
Бүгд:	10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Тогтоолын төслийн Хавсралтад тусгагдсан “Хэрэгжих хугацааг” доор дурдсанаар өөрчлөх:

“Хавсралтын 2 дахь хэсгийн 2.2.1 дэх мөрийн “2027” гэснийг “2028” гэж, 3 дахь хэсгийн 3.1.2 гэсэн мөрийн дараах “дугаарлаагүй” мөрийг “3.1.3” гэж дугаарлаж, уг мөрийн “2029” гэснийг “2028” гэж, 3.1.7 дахь мөрийн “2029” гэснийг “2028” гэж, 3.5.4 дэх мөрийн “2029” гэснийг “2028” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 14 минут үргэлжилж, ирвэл зохих 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 10 цаг 24 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн  
хууль” танхим 10 цаг 10 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Ганболд:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж байна аа.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Т.Энхтүвшин, Ж.Эрдэнэбат нар хүрэлцэн ирсэн байна ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг танилцуулъя.

Хуралдаанаар Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуух асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай”

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Я.Содбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Б.Даваадалай Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх, З.Мэндсайхан, Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх, Ж.Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, М.Дондогдорж ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын дарга, Ц.Амгалан ХХААХҮЯ-ны БХЗГ-ын ахлах мэргэжилтэн, Б.Эрхэмбаяр ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын ахлах мэргэжилтэн, Ч.Эрдэнэбат Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал, Т.Баярсайхан Арьс шир үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал гэсэн одоо хэлэлцэх асуудалтай холбогдуулж бүрэлдэхүүн ирсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дэмжсэн бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн. Тогтоолын төслийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд миний бие тогтоолын төслийн талаар санал гаргаж бичгээр ирүүлсэн байгаа. Улсын Их Хурлын гишүүн Ганболдоос ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж асуух асуулттай гишүүн байна уу? Энхтүвшин гишүүнээр тасалъя аа.

Туваан гишүүн асууя.

**Ц.Туваан:** Энэ маш чухал тогтоолын төсөл орж ирж байгаа.

Одоо Монгол Улсын эдийн засгийн одоо голлох салбар болсон хөдөө аж ахуй тэр дунд 85 хувийг нь бүрдүүлж байгаа энэ МАА-н салбар байгаа юм аа.

Тэгэхээр энэ МАА-н салбар дээр энэ малын гаралтай түүхий эд гэдэг одоо малчдын маань бүтээж өгч байгаа хамгийн чухал одоо бүтээгдэхүүн байгаа юм. Хөдөө орон нутгаар маш олон иргэдтэй уулзаад явж байхад ерөөсөө ярьдаг асуудлуудынх нь хамгийн одоо чухал хэсэг дотор бол энэ малын гаралтай түүхий эд гэдэг зүйлийг 2 асуудал болгоны нэг нь заавал ч үгүй ярьж байгаа юм. Юу хэлж байна гэхлээр бидний бэлдэж бэлтгээд өгсөн энэ арьс шир хог боллоо. Ноос ноолуурын үнэ бага байна өмнөхтэй харьцуулахад бага байна гэдэг асуудлыг нэлээн ярьж байгаа юм. Тэгэхээр бид бүхэн энэ дээр нэг их улс төржих юм байхгүй. МАН-ын түүхий эд АН-ын түүхий эд гэж байхгүй. Монгол Улсын л түүхий эд гэж байгаа.

Дээрээс нь 150 мянган орчим малчин өрхийн тэр орлогын амьжиргааны түвшин дээшлүүлэх гол одоо орлогоо олдог хэсэг бол энэ түүхий эд байсан. Одоо бол байхгүй болчихоод байгаа юм. Одоо ганцхан хаанаас орлогоо олж байна гэхлээр намар болохоор нэг мах хөлдөөд ирэхээр нэг мал нядалж мах зарж орлого олж байгаа. Нөгөө тал нь бол хавар ноолуур дээр нэг ноолуур борлуулж орлого олж байгаа. Тэгээд энэ жил шиг ийм сүүлийн 2 жил дараалан ялангуяа манай энэ Төв аймгийн хувьд сүүлийн жил чинь энэ Монгол Улсын 20 аймагт болчихлоо. Энэ байгалийн гамшигт үзэгдэл зуд энэ зүйлээр ингээд мал нь 10, 20 саяар

хорогдоод ирэхээр тэд нарын орлого талд бол маш том доголдол үүснэ ээ.

Тэгэхээр энэ доголдлыг энэ малын гаралтай түүхий эдийг үнэ цэнтэй болгож байж л бид нар гарах юм байгаа юм аа. Тэр одоо дахиад нэг зүйл хэлье. Дарханы арьс ширний цогцолбор бүрэн зогсчихсон 180 га газар дээр. Дахиад хажуу талд нь 25 га байхаа тэгж санаж байна. Тийм одоо газар авчхаад тэнд нь шинээр хийнэ ээ гээд иймэрхүү зүйлүүд явж байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ тэрний энэний гэхээсээ илүүтэйгээр нийлээд одоо маш яаралтай энэ төслүүдээ урагшлуулахгүй бол хоног хугацаа биднийг хүлээхгүй. Малчдын түүхий эд өнөөдөр ингээд үнэгүй л болоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол би улс төржихгүйгээр энийг урагшлуулъя.

Дээрээс нь энэ өнөөдрийн малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай энэ Их Хурлын тогтоолын төслийг маш хурдтайгаар дэмжээд баталсан нь зүйтэй гэдэг ийм саналыг хэлэх гэж байгаа юм. Тэгээд энд одоо бас жосоохон оройтлоо. Яг ний нуугүй хэлэхэд Их Хурал, Засгийн газар энэ хавар яг энэ чуулганы төгсгөл рүү энэ малчидтай холбоотой малчны тухай уур амьсгалын өөрчлөлт буюу зудын эрсдэлээс гарах тухай тэгээд дээрээс нь энэ МАА-тай холбоотой энэ одоо малчдын хоршоо ч байдаг юм уу, малчин өрхийн нэгдсэн холбоо ч байдаг юм уу ингээд баахан хуулиуд оруулаад ирж байгаа. Уг нь энийг бид нар цаг хугацаа байсан бол эртхэн яриад нэлээн энд энд тэндээс нь сайн аажуу тайван ярилцаж хэлэлцээд энэ асуудлыг яримаар байгаа юм. Тэгээд яг чухал өнөөдөр малчин болгоны ярьж байгаа асуудал бол ерөөсөө малчны зээл. Малчны хоршоо 2 л ярьж байна шүү дээ. Хоршооны асуудлыг бол дэмжиж байгаа. Малчид руу одоо хэдэн малчин ч гэсэн орлого олж байвал болж байгаа юм.

Харин нэг гол асуудал нь тэр мал барьцаалж авсан зээлээ өөрсдөө шууд захиран зарцуулах эрхгүйд нь жоохон гайхаад байгаа юм. Тэгэхээр дараагийн тэр одоо малчны зээл тэглэх малжуулах гэдэг энэ одоо хөтөлбөрүүд нь Их Хурал дээр оруулаад хэлэлцэгдэхгүй байгаа асуудлыг л жоохон гайхаад байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг дэмжиж байна тэгээд хурдан батлаарай.

**Г.Ганболд:** Санал хэллээ. Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Т.Энхтүвшин:** Энэ малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тогтоолын төслийг бол дэмжиж байна аа. Тэгээд ганц бодож байгаа зүйл юу вэ гэхээр ерөөсөө энэ дотоодын одоо онцгой байдал, цагдаа, цэрэг гээд төрийн тусгай чиг үүргийн их олон байгууллагууд байдаг. Энэ хэдийнхээ үйлдвэрийн хувцсыг л одоо хамгийн түрүүнд л одоо бэлдэж өгвөл дотоодын одоо энэ үйлдвэрлэл бас нэлээн хөгжих юм болов уу гэсэн ийм бодолтой байгаад байгаа. Тэгээд энэ тал дээр ер нь нэлээн онцгой анхаарах шаардлагатай болов уу гэсэн ийм бодолтой байж байна. Цаашидаа бид нар энэ түүхий эдээ эцсийн шатанд одоо боловсруулж байж л түүхий эдийн үнэ бас нэмэгдэнэ. Эцсийн шатанд одоо боловсруулж байж л бид нар дотоод эдий дотоодынхоо хэрэгцээг одоо хангах бололцоо боломж бас бүрдэнэ ээ. Сая одоо ковидын цар тахлын үед бол одоо Монгол Улс одоо үйлдвэрлэгч байх ёстой юм гэдгийг бол одоо харууллаа шүү дээ.

Тийм учраас сүү цагаан идээгээ, ноос ноолуураа, арьс ширээ гээд, хүнсээ гээд бүх зүйлээ л одоо дотооддоо үйлдвэрлэдэг болох ийм бололцоо боломжийг л бид нар цаашидаа бас бий болгож явах ёстой гэж бодож байна. Тэгээд энэ тогтоолын төслийг бол дэмжиж байна аа.

**Г.Ганболд:** Энхтүвшин гишүүн санал хэллээ.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал нэг тогтоолын төслийн 5 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганболд.

Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн Хавсралтад тусгагдсан “Хэрэгжих хугацааг” доор дурдсанаар өөрчлөх:

“Хавсралтын 2 дахь хэсгийн 2.2.1 дэх мөрийн “2027” гэснийг “2028” гэж, 3 дахь хэсгийн 3.1.2 гэсэн мөрийн дараах “дугаарлаагүй” мөрийг “3.1.3” гэж дугаарлаж, уг мөрийн “2029” гэснийг “2028” гэж, 3.1.7 дахь мөрийн “2029” гэснийг “2028” гэж, 3.5.4 дэх мөрийн “2029” гэснийг “2028” гэж тус тус өөрчлөх, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганболд.

Санал хураалт.

80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганболд.

Санал хураалт.

80 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.



*Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна аа.*

*Байнгын хорооны хурал өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрсдөгийг мэдэгдье ээ.*

*10.24 цагт*

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**  
**П.МЯДАГМАА**